



# СОЁМБО МЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№60 /504/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.04.13

Цаг үе, үйл явдал

## ЦЭРГИЙН СЭТГҮҮЛЧ, ЗУРАГЛААЧ НАРЫГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТАД ХАМРУУЛАВ



Батлан хамгаалах яамнаас Хэвлэлийн хүрээлэнтэй хамтран цэргийн сэтгүүлчдийг чадавхжуулах сургалтыг 4 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгууллаа.

Сургалтад БХЯ, ЗХЖШ, ХЗЦК-ын хэвлэл, олон нийттэй харилцах ажилтнууд, "Соёмбо" редакцын бүрэлдэхүүн хамрагдсан бөгөөд Хэвлэлийн хүрээлэнгийн сургагч багш Б.Туул, Б.Мөнгөнзаяа, Т.Есөн-Эрдэнэ нар "Олон нийт гэж хэн бэ", "PR-ийн тухай ойлголт", "Хэвлэлийн мэдээ, орчин үеийн загвар, бүтэц", "Сошиал медиаг үр дүнтэй ашиглах нь", "Сошиал медиад зориулсан сонирхолтой, үр нөлөөтэй баннер, пост бэлтгэх аргууд", "Гар утсаар бичлэг хийх, контент бэлтгэх нь" сэдвээр мэдээлэл өгч, бүлгээр дадлага ажил гүйцэтгүүлсэн юм.

Тухайлбал, Б.Туул багш сургалтынхаа эхэнд "Аливаа байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, таниулахад хэвлэлийн төлөөлөгч, салбарын сэтгүүлч нарын үүрэг асар их. Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, цэрэг-эх оронч үзэл хүмүүжлийг түгээн дэлгэрүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажил цэргийн сэтгүүлчид та бүхний нуруун дээр яваа гэдэгтэй хэн ч маргахгүй. Гэхдээ олон нийтэд салбарынхаа мэдээ мэдээллийг илүү хүртээмжтэй, зөв оновчтой хүргэхийн тулд цэргийн сэтгүүлчдээ улам чадавхжуулах ёстой гэдэгтэй оновчтой сургалтыг зохион байгуулах санал тавьсан Батлан хамгаалах яамныханд талархал

илэрхийлье" гээд байгууллагын сурталчилгаа, мэдээллийн эх сурвалж, хэвлэлийн мэдээ болон хэвлэлийн бага хурал бэлтгэж зохион байгуулах дарааллын талаар ярилаа.

Тэрээр салбарын сурталчилгаа гэдэг зөвхөн тухайн байгууллагын үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй. Хамтран ажилладаг байгууллага, иргэд, залууст эерэг сэтгэгдэл төрүүлсэн контентууд ч энэ салбарыг сурталчилж чаддаг. Үүнийг соргогоор мэдэрч, салбарынхаа мэдээлэлтэйгээ зэрэгцүүлж явахыг хичээх хэрэгтэй. Хэвлэлийн бага хурал гэдэг бусдад итгэл үнэмшил төрүүлэх, албан ёсны байр сууриа илэрхийлэх гол "тайз" учраас төрийн байгууллагууд үүнийг ашиглаж байх нь зөв. Ямар нэгэн асуудалд хариу өгөхгүй чимээгүй байх нь олон нийтэд алдаагаа хүлээн зөвшөөрч гэж ойлгогддог учир хэвлэлийн бага хурал хамгийн оновчтой шийдвэр" гэж онцоллоо. Үүний дараа Б.Мөнгөнзаяа, Т.Есөн-Эрдэнэ нар ярилцагчтайгаа хэрхэн харилцах, сэдэв өнцгөө хэрхэн барих, түүнийг гоо сайхныг хөндөөгүй, өөрийнх нь зөвшөөрөлтэй гэрэл зургийг ашиглах ёстойг дурдаж, сэтгүүлч хүн алхам тутамдаа ёс зүйтэй байх бичигдээгүй хууль үйлчилж байдгийг тодотголоо.

Мөн сошиал медиагаар дамжуулан цэрэг дайчдаа хэрхэн сурталчлах, богино хэмжээний дүрс бичлэг, контентыг гар утсаар яаж бэлтгэхийг дадлага ажлаар гүйцэтгүүлж, сургаж, Сургалтын төгсгөлд Монгол Улсын Засгийн газрын

гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, бригадын генерал Ж.Болдбаатар уулзаж, тодорхой асуудлаар үүрэг чиглэл өглөө.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд олон нийтээс өгөх үнэлгээ, дүгнэлт нь та бүхний ажил үйлсээр илэрч байдаг онцлогтой. Тийм ч учраас ажил авсан даруйдаа "Соёмбо" сонин, "Дуулга" телестудийг нэгтгэж "Соёмбо" редакц гэсэн нэгдсэн бүтэцэд оруулж, зарим төрлийн техник тоног төхөөрөмжөөр хангасан. Энэ ажил цаашдаа үргэлжилнэ. Тоног төхөөрөмжийн шинэчлэлээс гадна цэргийн сурвалжлагч, зураглаач, бусад мэргэжилтнүүдийг чадавхжуулж хөгжүүлэх болоод нийгмийн хамгааллын талд нь ч анхаарна. Энэ төрлийн сургалтыг тогтмол зохион байгуулж байх нь зөв юм. Хамгийн гол нь цэргийн сурвалжлагч гэдэг салбарынхаа нүүр царай, илэрхийлэл болж байдгийг ямагт санаж, ёс зүй, сахилга бат, биеэ авч явах соёл, мэдлэг чадвараараа үргэлж манлайлагч байхад онцгой анхаар. Орчин үеийн өөрчлөлт хөгжилтэй хөл нийлүүлж, залуусын сонирхлыг татсан, цэргийн албыг сурталчилсан нийтлэл, нэвтрүүлэг бүтээх ажлаа улам эрчимжүүл. Та бүхний ажил албыг удирдлагын зүгээс үргэлж дэмжих болно" гээд сургалтад хамрагдсан бүрэлдэхүүнд сертификат гардуулан өгсөн юм.

Ахмад Д.БОЛОР



## ЭЛЧИН САЙД ЗАФЕР АТЕШИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Зафер Атешийг хүлээн авч уулзав.

Уулзалтын үеэр Элчин сайд З.Атеш Бүгд Найрамдах Турк Улсын зүүн өмнөд бүс нутагт болсон хүчтэй газар хөдлөлтийн гамшгийн хүнд цаг үед хүмүүнлэгийн яаралтай тусламж үзүүлсэн Монгол Улсын Батлан хамгаалах яаманд талархал илэрхийлсэн юм.

Түүнчлэн "Хүнд хэцүү цагт тусалсан Монголын ард түмний тусыг Туркийн ард түмэн хэзээ ч мартаггүй, Та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье" хэмээсэн талархлын бичгийг гардуулав.



### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 685,273,221

Эдгэрсэн

Нийт: 658,075,477

Нас барсан

Нийт: 6,839,960

2023.04.13 /ПҮРЭВ ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 23

ХАВРЫН ДҮНД ХӨХӨГЧИН ТУУЛАЙ САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:

Эд эдлэл, идээ ундаа олдоно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.08-19.38

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Авахуй

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлгийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эд эдлэл барагдах, хулгай, дээрмийг дарах тэргүүтэнд махаши тэнгэрээс гаслан ирэх тул хэрэг тус үл бүтнэ, эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой.

Цахим шууданд

# АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТӨӨР СУРГАЛТ ЯВУУЛЛАА



болсон, хэн хэн оролцсон талаар бичих бөгөөд 15, түүнээс дээш хүн оролцсон бол нэрийн жагсаалтыг тусад нь үйлдэж, тэмдэглэлд хавсаргана.

Албан бичгийн бичвэр нь үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Нэгдүгээр хэсэгт уг баримт бичгийг зохион бүрдүүлсэн зорилго, үндэслэл, шалтгаан, хоёрдугаар хэсэгт санал, хүсэлт, дүгнэлт, шийдвэрийг тодорхой тусгана. Албан бичгийг хариуцсан ажилтан боловсруулж, эрх хэмжээнийхээ хүрээнд байгууллагын дарга, эсхүл чиг үүргийнхээ хүрээнд бүтцийн нэгжийн удирдлага гарын үсэг зурж, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулна.

Ингэхдээ дарагдах тамга эсвэл тэмдэг нь албан тушаалын бичиглэл дээр бус гарын үсэг оролцуулан бүрэн, тод, эгц байх ёстойг сануулав.

Төгсгөлд нь шинэчлэгдсэн дүрмээр албан бичиг төлөвлөхөд хэрхэн анхаарах тухай нарийвчлан заасныг онцолж, жишээ татан ярилаа. Тухайлбал, та бүхэндээ нийтлэг үйлдэгддэг албан бичигт дэд ахлагч Батаа овогтой Намуунааг сэлгэн ажиллуулах саналтай байна гэдгийг дэд ахлагч Батаагийн Намуунаа гэж бичнэ гээд алба хаагчдын сонирхсон асуултад хариуллаа.

Энэхүү сургалтын дараа командлалын Удирдлага төлөвлөлтийн хэлтсээс "Эрүүл, аюулгүй ажлын байр, бидний хөгжил" сэдвээр 21 хоногийн аянг дотооддоо зохион байгуулж эхэлснийг онцлов. Энэ нь алба хаагчдад зөв хэвшил дадлыг бий болгох, өөрийн эрүүл мэнд болоод албаны хандлагыг дээшлүүлэх, манлайллыг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд аяны эхэнд "Эрүүл мэндийн зөв дадал, хэвшил" сэдвээр Эрүүл ахуйн эмч ахлах дэслэгч Х.Гарьд мэдээлэл өгсөн юм.

Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг удахгүй явагдахтай холбогдуулан Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас бие бүрэлдэхүүндээ "Баримт бичгийг стандартын дагуу зохион бүрдүүлэхэд тавигдах шаардлага" сэдвийн хүрээнд дөрөвдүгээр сарын 11-ний өдөр сургалт зохион байгууллаа. Сургалтыг "Монголын архивчдыг дэмжих холбоо" төрийн бус байгууллагын нарийн бичгийн дарга, "Архивчдын хөгжил" сургалтын төвийн сургагч багш Н.Батхшиг удирдан явуулсан бөгөөд тэрээр шинэчлэн батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болоод "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын хүрээнд мэдээлэл өгч, алба хаагчдын сонирхсон асуултад хариулав.

Тэрээр "Баримт бичгийг зохион бүрдүүлэхдээ монгол хэлний өгүүлбэр зүй, найруулга, зөв бичих

дүрэмд нийцсэн, энгийн, хоёрдмол утгагүй, аман ярианы болон нутгийн аялга хэлцгүй байна. Мэдээллийн эх сурвалж, хуулийн хүчинтэй байх шаардлагад нийцсэн байна" гээд акт, дүгнэлт, илтгэх хуудас, танилцуулга, зөвлөмж, санал зэргийг ямар стандарт бичиж албажуулах талаар тайлбарлав.

Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журамд заагдсанчлан "Ariai" фонт бол 11-12, "Times new roman" фонт 12-14 хэмжээтэйгээр ашиглах ба хүснэгтэн мэдээллийн үсгийн хэмжээ 9-11 байх ёстой, аливаа хурал, зөвлөгөөн, уулзалт, яриа, хэлэлцээрийн явц, шийдвэрийг хэлэлцсэн асуудал тус бүрээр тодорхойлон тэмдэглэл хөтөлнө. Хуралдааны тэмдэглэл нь эхлэл болон "Хэлэлцсэн нь", "Сонссон нь", "Шийдвэрлэсэн нь" гэсэн дарааллаар, хэлэлцсэн асуудал тус бүрээр бичигдэнэ. Эхлэл хэсэгт хуралдаан хэзээ, хаана

## УЛАМЖЛАЛТ НААДГАЙГАА ТОГЛОЖ СУРЦГААЛАА



Завхан аймгийн Улиастай сумын музейн хамт олон Зэвсэгт хүчний 325 дугаар ангид ажиллаж Монгол ардын уламжлалт наадгай болох "Үйчүүр" тоглоомыг ирээдүй хойч үедээ сурталчлан таниулах ажлыг зохион байгуулжээ.



## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ЭМЧ НАР ГОВЬ-АЛТАЙ АЙМАГТ АЖИЛЛАЖ БАЙНА



Цэргийн төв эмнэлгийн эмч нар Батлан хамгаалахын сайдын тушаалаар Говь-Алтай аймагт ажиллаж байна.

Тус бүрэлдэхүүн нь цэрэг татлагатай холбогдуулан цэрэг татлагын товчооны эмч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, харилцан мэдээлэл солилцох, цэргийн албанд тайван цагт эрүүл мэндээр тэнцэхгүй цэргийн насны залуучуудыг эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөх зорилгоор ажиллаж байгаа юм.

# АНГЛИ ХЭЛНИЙ ОЛИМПИАДЫГ ЗОХИОН БАЙГУУЛНА



Алба хаагчдын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, гадаадын сургууль, дамжаа, НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр бэлтгэгдэж байгаа цэргийн алба хаагчдад дэмжлэг үзүүлэх, гадаад хэл сурах хүсэл эрмэлзлийг идэвхжүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас харьяа нэгтгэл, ангиудын бүрэлдэхүүний дунд "Англи хэлний олимпиад-2023" тэмцээнийг зохион байгуулахаар болжээ.

Тэмцээн хоёр үе шаттайгаар явагдана. Нэгдүгээр шат нэгтгэл, ангид явагдаж, 2 цэргийн алба хаагчийг шалгаруулах бөгөөд хоёрдугаар шат нь 04 дүгээр сарын 26-ны өдөр командлалын байрлалд болно.

Олимпиадад Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиас мэргэжил харгалзахгүйгээр хугацаат болон цэргийн гэрээт алба хаагч, ахлагч, офицер аль нь ч оролцох боломжтой ба тэдний унших, бичих, сонсох, орчуулах чадвараар нь өрсөлдүүлэх ажээ.

## ЦЭРГИЙН ЖИНХЭНЭ АЛБАНД ЭРҮҮЛ МЭНДЭЭР ТЭНЦЭХГҮЙ ИРГЭДИЙГ ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАНААС ЧӨЛӨӨЛЛӨӨ



Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан "Иргэний цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-ын дагуу цэргийн эмнэлгийн комисс, аймгийн эрүүл мэндийн байгууллагын нарийн

мэргэжлийн эмч нарын дүгнэлтийг үндэслэн эрүүл мэндийн шалтгаанаар цэргийн албанд тэнцэхгүй иргэдийг үзлэгт хамруулж, тайван цагт цэргийн албанаас чөлөөлөх ажлыг зохион байгууллаа.

**ДОРНОД АЙМГИЙН ЦЭРГИЙН ШТАБ**

